



**ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ БАНК МОНГОЛ  
УЛСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ  
ҮҮСЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮДИЙН ТАЛААР**

*Боловсруулсан: ХШГ, БӨБХ-ийн ахлах хянан шалгагч Г.Борхүү*

*Энэ судалгаанд дурдагдсан аливаа дүгнэлт, дэвшүүлсэн санал нь зөвхөн зохиогчийн хувийн байр суурийг илэрхийлэх бөгөөд Монголбанкны байр суурийг заавал илэрхийлэх албагүй болно.*

Гадаадын хөрөнгө оруулалттай санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, өмчлөлийн бүтэц, удирдлагын зохицуулалтаас үүсэх эрсдэл, давуу ба сул талуудын талаар олон улсын түвшинд хийгдсэн судалгаа, дүгнэлтүүдэд<sup>12</sup> үндэслэн гадаадын банкинд Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгоход доор дурдсан чиглэлүүдэд анхаарал хандуулах нь зүйтэй байна. Үүнд:

### Гадаадын банкны үйл ажиллагаатай холбоотой нийтлэг дүгнэлт

Сүүлийн жилүүдэд хөгжиж буй улс орнуудын санхүүгийн систем дэх гадаадын банкуудын үйл ажиллагаа өргөжих болсон нь дараах түгээмэл шалтгаантай байна. Үүнд:

1. Дотоодын санхүүгийн зах зээл дээрх гадаадын банкуудад тавигдах шаардлагууд багассан
2. Техник, технологийн дэвшил хурдацтай явагдах болсон
3. Банкны системийн хямралын дараах санхүүжилтийн хэрэгцээ ихэссэн
4. Төрийн өмчит банкуудын хувьчлал явагдах болсон
5. Санхүүгийн интеграцчлал буюу дэлхийн санхүүгийн төвүүдийн харилцан хамааралтай байдал ихэссэн.

Хэдийгээр гадаадын банк нь өөрийн харьяа улс болон зорилтот дотоодын зах зээлд явуулах үйл ажиллагааны зүй тогтлын хувьд харилцан адилгүй боловч хөгжиж буй орнууд, ялангуяа Латин Америк, Зүүн Европ болон Африкийн орнууд дахь дотоодын **санхүүгийн байгууллагуудын дүрмийн сангийн хувьцаанд хөрөнгө оруулан** үйл ажиллагаа явуулсан тохиолдлууд түгээмэл байна. Харин хөгжиж буй орнуудад шинээр банк байгуулж үйл ажиллагаа явуулж байсан тохиолдлууд харьцангуй цөөн байна.

<sup>12</sup> ОУВС, Дэлхийн банк, Америкийн хөгжлийн банкны судалгаа, Claeyns, S., & Hainz, C. (2006). 17. Foreign banks in Eastern Europe: mode of entry and effects on bank interest rates. *Financial Development, Integration and Stability: Evidence from Central, Eastern and South-Eastern Europe*, 305.  
 Claeyns, S., & Hainz, C. (2007). Acquisition versus greenfield: The impact of the mode of foreign bank entry on information and bank lending rates.  
 De Haas, R., & Naaborg, I. (2005). Does foreign bank entry reduce small firms' access to credit? Evidence from European transition economies. *Working Papers*.  
 Demirguc-Kunt, A., Levine, R., & Min, H. G. (1998). Opening to Foreign Banks: Issues of Stability, Efficiency, and Growth.  
 McFadden, C. (1994). *Foreign banks in Australia*, The World Bank. mimeo.  
 Giannetti, M., & Ongena, S. (2009). Financial integration and firm performance: Evidence from foreign bank entry in emerging markets\*. *Review of Finance*, 13(2), 181-223.  
 Peria, M. S. M., & Mody, A. (2004). How foreign participation and market concentration impact bank spreads: evidence from Latin America. *Journal of Money, Credit and Banking*, 511-537.  
 Unite, A., & Sullivan, M. (2001). The impact of liberalization of foreign bank entry on the Philippine domestic banking market. *Philippine Institute PASCN discussion paper*, 8.

**Гадаадын банк байгуулах зохион байгуулалт болон өмчлөлийн хэлбэрүүд**

Дээр дурдсаны дагуу гадаадын санхүүгийн байгууллага нь салбарт нэвтрэх аргачлалын хувьд дотоодын банкинд хөрөнгө оруулах, эсвэл шинээр банк байгуулж болдог бол зохион байгуулалтын хэлбэрийн хувьд **салбар, охин компани** эсвэл **төлөөлөгчийн газар** хэлбэрээр үйл ажиллагаа явуулах боломжтой бөгөөд холбогдон гарч болзошгүй давуу болон сул талуудыг доорх хүснэгтэд харуулав.

**Хүснэгт 1. Гадаадын банкуудын зохион байгуулалтын бүтцийн ялгаа**

Хуулийн этгээдийн статус	ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
ОХИН КОМПАНИ	<ul style="list-style-type: none"> <li>▪ Монгол улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана;</li> <li>▪ Төв банкны хувьд бүрэн хяналт тавих боломжтой;</li> <li>▪ Хуулийн этгээд байх учраас Монгол улсад орлогын албан татвар төлнө;</li> <li>▪ Дотоодын банкуудтай ижил төрлийн үйл ажиллагаа явуулах, улмаар дотоодын зах зээлийн цар хүрээг өргөтгөж, өрсөлдөөнийг нэмэгдүүлж, эх үүсвэрийн хүүг бууруулах боломжтой;</li> <li>▪ Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, технологийг нэвтрүүлэх замаар үр ашгийг дээшлүүлж, санхүүгийн дэд бүтцийг сайжруулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Дүрмийн сангийн хэмжээнээс хамааран том зээл олгох боломж хязгаарлагдмал учир жижиг зээлийн зах зээл дээр дотоодын банкуудтай өрсөлдөнө;</li> <li>▪ Санхүүжилтийн өртөг нь салбар байгуулах сонголтоос өндөр <b>буюу өөрийн хөрөнгийн шаардлагад нийцүүлэн</b> бага хүүтэй, урт хугацаатай зээл олгох нь хязгаарлагдмал;</li> <li>▪ Эх үүсвэр татах үйл ажиллагааны зөвшөөрөлтэй тохиолдолд дотоодын зах зээл дэх өрсөлдөөний нөлөөгөөр хадгаламжийн хүүг улам нэмэгдүүлж болох талтай;</li> <li>▪ Эдийн засгийн хямралын үед толгой банкнаас дэмжлэг авахад хугацаа шаардлагатай, дэмжлэг үзүүлэхгүй байж болзошгүй;</li> <li>▪ Зэрэглэл тогтоодог байгууллагаар толгой компаниас тусдаа зэрэглэл тогтоолгох шаардлагатай болно.</li> <li>▪ <b>Хямралын үед охин компаниар дамжуулан олгож байсан санхүүжилт саатах, улмаар бодит салбарт хэлбэлзэл үүсгэх</b></li> </ul>

<p>САЛБАР, НЭГЖ</p>	<ul style="list-style-type: none"> <li>▪ <b>Эдийн засгийн хямралын үед толгой компаниасаа санхүүгийн дэмжлэг хурдан хугацаанд авч, эрсдэлээс хамгаалагдах боломжтой;</b></li> <li>▪ Охин компанид тавигдах өөрийн хөрөнгийн хязгаарлалт үйлчлэхгүй тул олгох зээлийн хэмжээг, илүү таатай нөхцөлтэйгээр олгож болох талтай;</li> <li>▪ Толгой компанийн зээлжих зэрэглэлтэй адил байх;</li> <li>▪ Толгой компани нь санхүү, төлбөрийн чадвар, бүх үүрэг хариуцлага, алдагдлыг хүлээнэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Төв банк зохистой хяналт тавих боломж хязгаарлагдмал;</li> <li>▪ Төв банк шууд харьцах, шаардлагатай мэдээлэл авах боломж хязгаарлагдмал;</li> <li>▪ Зөвхөн толгой компанийхаа заавар журмыг мөрдөнө.</li> <li>▪ Хадгаламж татах зөвшөөрөл авсан тохиолдолд хадгаламжийн хүүгээр өрсөлдөж, дотоодын банкуудыг зах зээлээс шахаж болзошгүй;</li> <li>▪ <b>Хямралын үед салбар компаниар олгож байсан санхүүжилт гэнэт зогсох, улмаар бодит салбарт хэлбэлзэл үүсгэх</b></li> </ul>
<p>ТӨЛӨӨЛӨГ- ЧИЙН ГАЗАР</p>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Гадаадын банкны үйл ажиллагааны талаар дотоодын зах зээлд сурталчлах таниулах;</li> <li>▪ <b>Бизнес эрхлэгчид, санхүүгийн байгууллагуудыг өөрийн толгой болон бусад улс орнууд дахь сүлжээ компаниудад зуучлах.</b></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ <b>Хямралын үед төлөөлөгчийн газраар дамжуулан олгож толгой эсвэл зэргэлдээ байгууллагаас олгож байсан санхүүжилтийн урсгал гэнэт зогсох, улмаар бодит салбарт хэлбэлзэл үүсгэх;</b></li> </ul>

### Үр ашиг, өрсөлдөөний нөлөө

Гадаадын санхүүгийн байгууллагуудын дотоодын санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөллийн талаар хийгдсэн зарим судалгаанаас харахад гадаадын томоохон санхүүгийн байгууллагуудын өндөр чанартай технологи<sup>13</sup>, хүний нөөцийн мэргэжлийн ур чадвар, үнэ багатай бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлснээр банкны салбарын үр ашгийг нэмэгдүүлж, салангид, ялгаатай үйлчилгээ үзүүлдэг байсан байдлаас санхүүгийн нэгдсэн буюу нэг цэгийн цогц бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдад санал болгох сонголтыг бий болгох эерэг нөлөөтэй гэж дүгнэсэн байна<sup>14</sup>. Нөгөө талаас, гадаадын банкууд хөнгөлөлттэй нөхцөлтэй бүтээгдэхүүн үйлчилгээг өрсөлдөөн нэрийдлээр хэт түрэмгий байдлаар санал болгох нь дотоодын банкуудын үйл ажиллагаанд дарамт учруулж тэднээс олгох зээлийг багасган зах зээлээс шахах, улмаар нийт системийн хэмжээний зээлийн өсөлтийг бууруулах нөлөө үзүүлэх боломжтой байдаг<sup>15</sup>. Өөрөөр хэлбэл, дотоодын банкны салбар зээл болон эх үүсвэрийн хувьд цөөн тооны томоохон гадаадын банкуудад их хэмжээгээр төвлөрөх эрсдэлтэй.

<sup>13</sup> Claessens 2001 - How does foreign entry affect domestic banking market?

<sup>14</sup> Geldos Roldos 2004 - Consolidation and market structure in emerging market banking systems

<sup>15</sup> Gormley 2010 - **The Impact of Foreign Bank Entry in Emerging Markets: Evidence from India**

**Иймээс эрсдэлээ тархаан байршуулж, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх санхүүгийн эх үүсвэр хангалттай, гадаадын нэр хүнд бүхий банкуудтай дотоодын банкууд хамгийн багадаа төлбөрийн чадварын үзүүлэлтээ хангах хэмжээнд өрсөлдөх чадвартай болох хүртэл тодорхой хугацаа шаардлагатай юм.**

### **Хувийн салбарт олгох санхүүжилт**

Энэ сэдвээр хийгдсэн эмпирик судалгаагаар дотоодын банкууд нь удаан хугацаанд түншлэлийн харьцаа тогтоосон найдвартай, танил, цөөн тооны зээлдэгч нарт зээлээ төлөх чадвар дутмаг байгааг үл харгалзан санхүүжилтийг түлхүү олгодог хандлага байдаг<sup>16</sup>. Харин гадаадын банк уг зах зээлд нэвтэрснээр санхүүжилт өмнө нь авч чадаагүй байсан харилцагчдад шинэ санхүүгийн эх үүсвэрийг олгох боломжоор ханган, дотоодын банкуудын дунд өрсөлдөөнийг нэмэгдүүлэх эерэг нөлөө үзүүлдэг талаар судалгаанд дурдсан байна<sup>17</sup>. Хэдийгээр санхүүгийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж сайжрах боломжтой боловч зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулах гадаадын банкны бизнесийн загвар, үйл ажиллагааны чиглэл, өрсөлдөөний стратеги болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан дотоодын банкуудаар үйлчлүүлж буй одоогийн харилцагчдыг татах, цөөн тооны харилцагчдад үйлчлэх буюу санхүүжилт хэрэгцээтэй байгаа шинэ харилцагчдад үйлчилгээ үзүүлэхгүй байх боломж ч байна.

Гэсэн хэдий ч, ихэнх тохиолдолд гадаадын банкууд нь хэмжээ, цар хүрээний хувьд харьцангуй том зээлдэгч нарт санхүүжилт олгох хандлагатай болдог. Гадаадын банкуудын нөлөөллөөр дотоодын банкуудын үйл ажиллагаа хязгаарлагдмал болсон тохиолдолд жижиг, шинэ бизнес эрхлэгчдийн санхүүжилтэд хамрагдах боломж багасах эрсдэл байдаг.

### **Жижиг аж ахуй эрхлэгчид олгох санхүүжилт**

Онолын хувьд гадаадын санхүүгийн байгууллагууд дотоодын зах зээлд орохдоо зээлдэгчдийн албан ёсны тайлан, мэдээлэлд үндэслэн зээл олгодог бөгөөд ихэнх тохиолдолд томоохон зээлдэгчдэд үйлчлэх ба нээлттэй бус мэдээлэл ашиглах буюу хаалттай компаниудад үйлчлэх боломж хязгаарлагдмал байдаг. Үүний үр дүнд, банкны зээлдэгчдэд нь том, жижиг гэсэн сегментэд хуваагдаж, жижиг зээлдэгчдийн хувьд гадаадын банкуудын шаардлагад нийцсэн тайлан мэдээллийг нээлттэй болгох хүртлээ өмнө нь үйлчлүүлж байсан дотоодын байгууллагын үйлчилгээнд найдахад хүрдэг<sup>18</sup>.

<sup>16</sup> Luc Laeven 2001 - Banking Sector Performance in East Asian Countries: The Effects of Competition, Diversification, and Ownership

<sup>17</sup> Rajan, Zingale 2003 "Banks and Markets: The Changing Character of European Finance,"

<sup>18</sup> Dell'Arccia and Marquez 2005 - Lending Booms and Lending Standards

Энэтхэг улсын хувьд 1990-ээд онд шинээр орж ирсэн гадаадын банкууд нь зөвхөн ашигт ажиллагаа сайтай, хэмжээний хувьд томоохон, цөөн тооны зээлдэгч нарт үйлчилгээ үзүүлснээс нийт санхүүгийн систем дэхь хувийн салбарын зээл олголтын хэмжээ 8 хувиар буурсан. Энэ нь дотоодын банкуудаас олгох зээл багассантай холбоотой бөгөөд ихэнхдээ гадаад санхүүжилтээс хамааралтай, жижиг компаниуд энэ хүндрэлд түгээмэл өртөж байсан. Пакистан улсын хувьд мөн адил зүй тогтол ажиглагдсан ба гадаадын банкууд зөвхөн ашигт ажиллагаа сайтай зээлдэгчдэд л үйлчлэх хандлагатай байна. Гэхдээ зарим судалгаагаар дотоодын санхүүгийн зах зээл дэх гадаадын банкуудын оролцоо их байх тусам зээлдэгчдийн зүгээс санхүүжилт авахтай холбоотой хүндрэлүүд буурдаг гэсэн дүгнэлтүүд байдаг.

### **Тогтвортой байдалд үзүүлэх нөлөө**

Эрсдэлээ дотоодын банкуудтай харьцуулахад газар зүй, бүтээгдэхүүн үйлчилгээний хувьд тархаан байршуулах чадвар сайтай, шаардлагатай тохиолдолд толгой компаниас өөрийн хөрөнгийн санхүүжилт цаг алдалгүй авах боломжтой байдаг тул гадаадын банкууд нь дотоодын санхүүгийн зах зээлд учирсан хямрал, шокийг тогтворжуулах нөлөө үзүүлэх боломжтой<sup>19</sup>. Тухайлбал, Төв болон Зүүн Европын орнуудад үүссэн санхүүгийн хямралын үед дотоодын банкуудын зээл олголт хумигдсан байгаа бол гадаадын банкууд зээл, хадгаламжийн хэмжээг хэвийн түвшинд байлгаж үйл ажиллагаа явуулж байсан нь судалгаагаар нотлогдсон<sup>20,21</sup>.

Нөгөө талаас дотоод зах зээл дэх гадаадын банк нь дэлхийн бусад улсад үйл ажиллагаа явуулж буй толгой болон зэргэлдээ компаниудтай хувь эзэмшил болон төлбөрийн чадварын хувьд харилцан хамааралтай байдаг бөгөөд тухайн санхүүгийн нэгдлийн аль нэг хэсэгт санхүүгийн томоохон хүндрэл үүсэхэд тус шок нэгдлийн бусад зэргэлдээ компаниудад тархаж, улмаар дотоодын санхүүгийн зах зээлд бүтээгдэхүүн үйлчилгээ, хэвийн үйл ажиллагаа тасалдах, толгой компаниас эх үүсвэр яаралтай шилжүүлэх дарамт үзүүлэх зэргээс шалтгаалан дотоодын санхүүгийн салбарын тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй.

### **Хямралын тархах нөлөөлөл**

Сүүлд үүссэн санхүүгийн хямрал нь эдийн засгийн мөчлөг дагасан үйл хөдлөлтэй холбоотой байсан ба гадаадын банкууд нь дотоодын зах зээлд эдийн засгийн таатай үед мөчлөг дагасан байдлыг улам эрчимжүүлэх нөлөө үзүүлдэг.

<sup>19</sup> Peek, Rosengren 2000 - Troubled Banks, Impaired Foreign Direct Investment: The Role of Relative Access to Credit

<sup>20</sup> Da Haas, Lelyveld 2006 -Foreign banks and credit stability in Central and Eastern Europe. A panel data analysis

<sup>21</sup> Bruno, Hauswald 2009 - The Real Effect of Foreign Banks

Өөрөөр хэлбэл, дотоод дахь эдийн засгийн өсөлттэй үед гадаадын банкууд дотоодын банкуудтай адил зээл олголтын хэмжээг ихэсгэж, мөчлөг дагасан үйл хөдлөлийг нэмэгдүүлдэг.

Үүнээс гадна гадаадын банкууд нь өөрийн толгой компани байрших улсад эсвэл дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямрал гараагүй нөхцөлд дотоодын санхүүгийн зах зээлд үүссэн хямралыг тогтворжуулахад нөлөө үзүүлэх боломжтой байна.

**Зээлжилтийн өсөлт, бууралт (хөрөнгө оруулсан байршил болон эх үүсвэрийн хувьд)**

Доорх хүснэгтээр гадаадын болон дотоодын банкуудаас хөгжиж буй орнуудад байршуулсан санхүүжилт нь 2008-2009 оны санхүүгийн хямралаар хэрхэн өөрчлөгдөж байсныг харуулав.

**Хүснэгт 2. Зээл олголтын өөрчлөлт – Гадаадын банкны харьяалал ба байршуулсан улсаар**

Банкны харьяалал	Санхүүжилтийн төрөл	Хөгжиж буй Европ тив		Хөгжиж буй Ази тив		Латин Америк	
		2006-2007	2008-2009	2006-2007	2008-2009	2006-2007	2008-2009
Хойд америк	Олон улсын*	49.3%	10.6%	30.3%	40.6%	13.5%	21.8%
	Дотоодын**	36.1%	-4.5%	21.8%	6.5%	18.4%	-0.5%
Европ	Олон улсын	52.0%	-9.8%	27.0%	-21.5%	18.4%	-15.6%
	Дотоодын	55.1%	-10.6%	55.1%	-9.6%	31.6%	-4.1%
Ази	Олон улсын	29.1%	-16.1%	21.1%	-8.2%	28.1%	-3.3%
	Дотоодын	113.9%	-39.7%	12.7%	-6.2%	7.3%	-15.6%
Дотоодын банк	Олгосон зээл	32.1%	-21.3%	16.2%	14.6%	25.0%	-13.5%

\* - Хил дамнансан зээл ба дотоодын зах зээлд валютаар олгосон зээлийн нийлбэр буюу Хил дамнансан зээлийн үзүүлэлт  
 \*\* - Үндэсний валютаар дотоод зах зээлд олгосон зээл

Эх сурвалж<sup>22</sup>: Andrea F. Presbitero (2010)

Дээрх хүснэгтээс харахад 2008-2009 оны санхүүгийн хямралаас өмнө гадаадын санхүүгийн байгууллагуудаас дотоодын санхүүгийн системд олгох зээлийн өсөлт нь дотоодын банкуудаас их буюу мөчлөгийн далайцыг нэмэгдүүлж байсан бол санхүүгийн хямралын үеэр Ази болон Европын гадаадын банкуудын зээл олголт нь харьяа улс болон дотоодын захын аль алинд нь эрс буурсан байгааг харж болохоор байна. Өөрөөр хэлбэл гадаадын банкууд нь эдийн засгийн мөчлөгийг дагаж, хямрал үүсэх үед дотоодын санхүүгийн салбарын нөхцөл байдлыг хүндрүүлж байсныг ялангуяа Европ, Азийн харьяатай гадаадын банкуудын жишээнээс харж болохоор байна.

<sup>22</sup> Andrea F. Presbitero (2010) - Foreign banks in developing countries: main issues

Харин Америк улсын харьяалалтай гадаадын банкууд нь хямралын үеэр их хэмжээний санхүүжилтийг олон улс болон дотоодын зах зээлд эрчимтэй нэмэгдүүлж байсан байна.

### Монгол улсад гадаадын банкны үйл ажиллагааг явуулахад үүсч болзошгүй нөлөөллүүд

Хэдийгээр гадаадын банк, санхүүгийн байгууллагууд дотоодын зах зээлд нэвтэрч үйл ажиллагаагаа явуулснаар дээр дурдсан эерэг нөлөөллүүдийг үүсгэх боломжтой боловч энэ нь дотоодын банкуудын зах зээлийг эзлэх, тэдний өрсөлдөх чадвар, дархлааг сулруулах, багцын эрсдэлийг нэмэгдүүлэх, олигопол болон монопол өрсөлдөөнийг дэмжих, гадаадын банк, санхүүгийн байгууллагын харьяа улсын эдийн засгийн мөчлөгөөс хамаарах хамаарлыг нэмэгдүүлэх гэх мэт сөрөг үр дагаврууд гардаг болохыг дүгнэсэн байна.

Ойрын хугацаанд Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын банкны төлөөлөгчийн газруудаас банк байгуулах зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А-81 тоот тушаалаар Гадаадын банкны хувьд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 65.0 тэрбум төгрөгөөр буюу дотоодын банкуудад тавигдах 16.0 тэрбум төгрөгийн шаардлагаас 4 дахин ихээр тогтоосон байна. Энэ нь цаашид гадаадын банкуудаас нэг зээлдэгчдэд олгох зээлийн дээд хэмжээний хязгаар дотоод банкуудтай харьцуулахад харьцангуй өндрөөр тогтоогдох боломжтой ба илүү томоохон төслүүдийг санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэхээр байна.
- Гадаадын банкны үйл ажиллагааны зөвшөөрлийг Монголбанкны 2012 онд баталсан “Банкны зөвшөөрлийн журам”-д заасан шаардлагын дагуу олгох бөгөөд олон улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй, өндөр зэрэглэлтэй, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж буй нэр хүнд бүхий байгууллагууд байх зэрэг шаардлагуудыг тусгасан. Дээрх банкууд нь *economies of scope* буюу орлогын эх үүсвэрээ олон чиглэлээс бүрдүүлэх, *economies of scale* буюу хүлээж буй зардлаа дэвшилтэт тоног төхөөрөмж, хүний нөөц, дэд бүтцийн тусламжтайгаар бууруулан нэгж бүтээгдэхүүний зардлыг багасгах боломжтой бөгөөд улмаар дотоодын зах зээлд өрсөлдөөний харьцангуй давуу талыг үүсгэж болохоор болно.
- Дээрх давуу тал нь дотоодын санхүүгийн зах зээлд хоёр талын нөлөө үзүүлэх талтай. Нэг талаас дотоодын зах зээл дэх өрсөлдөөнийг нэмэгдүүлж зээл, хадгаламжийн дундаж хүүг бууруулж, улмаар бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэн бодит эдийн засгийг дэмжих боломжтой. Гэсэн хэдий ч Монголын санхүүгийн салбарт зээлийн хүү



өндөр байгаа нь улсын эрсдэл, өндөр инфляцийн түвшин болон бүтцийн шинжтэй олон асуудлаас шалтгаалж байгаа тул гадаадын банкуудад үйл ажиллагааны зөвшөөрөл олгон өрсөлдөөнийг нэмэгдүүлснээр зээлийн хүүг бууруулна гэсэн дүгнэлт хийх нь өрөөсгөл юм. Ялангуяа, бага өртөгтэй санхүүгийн бүтээгдэхүүнийг их хэмжээгээр нийлүүлснээс дундаж зардал өндөртэй дотоодын банкууд өрсөлдөөний дарамт шахалтад өртөн зах зээлээс шахагдаж, улмаар системийн нийт зээлийн хүртээмжийг бууруулах эрсдэл байна.

- Зээл олгох болон барьцаа хөрөнгөнд тавигдах стандарт шаардлагууд сул байх тохиолдолд гадаадын банкуудаас өрсөлдөгчдийг шахах зорилгоор эрсдэл даах чадваргүй их хэмжээний зээлийг санхүүжүүлэх үйл явцыг ихэсгэх, ингэснээр зээлийн эргэн төлөлт, чанарт тавигдах эрсдэлийн удирдлага муудан санхүүгийн тогтворгүй байдал үүсэх аюултай.
- Гадаадын банкуудаас их хэмжээний тогтворгүй хөрөнгийн урсгал өндөр давтамжтайгаар огцом орж, гарах нөхцөл бүрдэж болно. Ялангуяа гадаадын банкууд нь салбар хэлбэрээр үйл ажиллагаа явуулах тохиолдолд бусад дотоодын банкуудын үйл ажиллагааны тогтвортой байдал алдагдах, ихээхэн хэлбэлзэл үүсэх эрсдэл өндөр байна.
- Монгол улсын санхүүгийн зах зээл дээр 2008 оноос эхлэн гадаадын банк Төлөөлөгчийн газраа байгуулан үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 2014 оны 2 дугаар сарын байдлаар дээрх шалгууруудыг хангасан олон улсад нэр хүнд бүхий нийт 5 гадаадын банк Монголбанкны зөвшөөрөлтэйгээр “Төлөөлөгчийн газар”<sup>23</sup>-ын үйл ажиллагааг эрхэлж байна. Үүнд:

**Хүснэгт 3. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын банкуудын төлөөлөгчийн газрын талаарх мэдээлэл**

№	Гадаадын банкны Төлөөлөгчийн газар	Байгуулагдсан огноо
1	ING Bank N.V - Төлөөлөгчийн газар	2008 он 8 сар
2	Standard Chartered Bank- Төлөөлөгчийн газар	2012 он 7 сар
3	Bank of China - Төлөөлөгчийн газар	2012 он 12 сар
4	Sumitomo Mitsui Banking Corporation - УБ дахь Төлөөлөгчийн газар	2013 он 7 сар
5	Bank of Tokyo Mitsubishi UFJ - УБ дахь Төлөөлөгчийн газар	2013 он 12 сар

“Банкны зөвшөөрлийн журам”-д заасны дагуу дээрх Төлөөлөгчийн газрууд нэгээс доошгүй жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулсан бол банкны үйл ажиллагааг эрхлэх хүсэлтээ Монголбанк болон бусад эрх бүхий байгууллагуудад

<sup>23</sup> МБЕ-ийн 2012 оны А99 дүгээр тушаалаар баталсан “Банкны нэгжийн журам”-ын 1.2.6.-д “Банкны төлөөлөгчийн газар” гэж банкны аливаа үйл ажиллагаа эрхэлдэггүй, банкны оршин байгаа газраас өөр газар байрладаг бөгөөд банкны хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулах нэгжийг хэлнэ.

тавих эрхтэй болох бөгөөд банкны үйл ажиллагааг хуулийн этгээдийн статустай эрхэлж болохоор зохицуулсан болно. Өөрөөр хэлбэл гадаад улсын хуулийн этгээд Монгол улсад банкны үйл ажиллагаа эрхлэх бол өөрийн охин компаниараа дамжуулан эрхлэх боломжтой болсон.

- Дээрх хүснэгтээс харахад Bank of Tokyo Mitsubishi UFJ-ээс бусад гадаадын банкны төлөөлөгчийн газрууд нь нэгээс дээш жил үйл ажиллагаа явуулсан тул банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ Монголбанкинд хүргүүлэх боломж нь нээгдсэн байна.
- Дээрх гурван төлөөлөгчийн газраас Bank of China банк нь төрийн оролцоотой буюу хувь эзэмшлийн ихэнх буюу 67.7 хувийг<sup>24</sup> Хятадын засгийн газрын эзэмшлийн Central Huijin Investment Ltd компани эзэмшдэг байна.
- Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21.1-д заасны дагуу Банк, санхүүгийн салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд засгийн газраас зөвшөөрөл авахаар заасан. Хэрвээ банк байгуулах тусгай зөвшөөрөл хүсэлт тавих нөхцлийг хангасан дээрх гурван төлөөлөгчийн газруудын аль нэг, ялангуяа төрийн өмчтэй Bank of China-аас банк байгуулах зөвшөөрөл хүсэх тохиолдолд холбогдох хүсэлтээ эхлээд Засгийн газарт, Засгийн газар зөвшөөрсөн тохиолдолд Монголбанкинд ирүүлэх шаардлагатай юм. Монголбанкны зүгээс уг хүсэлт нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн эсэх, дотоодын хууль тогтоомж, бизнесийн тогтсон хэм хэмжээг сахин биелүүлэх нөхцлийг хангасан эсэх, санхүүгийн салбарт өрсөлдөөнийг хязгаарлах, давамгайл байдал тогтоох болон Монгол Улсын төсвийн орлого, бусад бодлого, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэлтэй эсэх, товчхондоо эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллүүдийг сайтар судалж харгалзан үзэх нь зайлшгүй юм.
- Хүснэгт 3-т харуулсны дагуу Bank of China-ийн төлөөлөгчийн газраас банк байгуулах хүсэлтээ Монголбанкинд ирүүлэх тохиолдолд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.11-т заасан “Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд”-ийн тодорхойлолтыг хангасан<sup>25</sup> байх тул Эдийн засгийн хөгжлийн яаманд эхний ээлжинд хүсэлтээ гарган холбогдох зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

<sup>24</sup> 2014 оны 3 сарын 31-ний байдлаар [http://www.bankofchina.com/en/investor/ir4/201311/t20131114\\_2637872.html](http://www.bankofchina.com/en/investor/ir4/201311/t20131114_2637872.html)

<sup>25</sup> Хуулийн холбогдох заалтад нийт гаргасан хувьцааных нь 50, түүнээс дээш хувийг гадаад улсын төр шууд болон шууд бусаар эзэмшиж байгаа хуулийн этгээд гэж тодорхойлсон.

- Үүнээс гадна дээрх банкуудад хянан шалгахтай холбоотой хүндрэлүүд үүсч болохоор байна. Тухайлбал, бусад улсуудын жишгээр олон улсын санхүүгийн нэгдлийн гадаад дахь (жишээ нь Монгол улс) салбар, охин компанид хийх хяналт шалгалт, зохистой харьцааны шаардлагыг толгой компаний харьяа улсын эрх бүхий байгууллага хариуцаж, хяналт шалгалтыг гардан хийдэг. Зарим тохиолдолд охин компаний үйл ажиллагаа явуулах хяналтын байгууллагатай хамтарч ажилладаг. Энэ тохиолдолд гадаадын банкуудын зүгээс хяналтын арбитраж буюу хоёр улсын хоорондох хууль зүйн давуу байдлыг зүй бусаар ашиглах, зөрчлөө нуун дарагдуулах эрсдэлүүд үүсч байдаг.

## ДҮГНЭЛТ

Гадаад улсын нэр хүнд бүхий санхүүгийн нэгдлээс Монгол Улсад салбар, нэгжээ нээн үйл ажиллагаа явуулах асуудлыг Монгол улсын санхүүгийн салбар, эдийн засгийн тогтвортой байдалд учруулах эрсдэл, эерэг, сөрөг нөлөөллүүд болон ирээдүйн бусад үр дагавруудыг харгалзан үзэж шийдвэрлэх нь зүйтэй.

Ялангуяа, дотоодын зах зээлд үйл ажиллагаа явуулж буй банкуудын төлбөрийн чадварыг алдагдуулах, өрсөлдөөний давуу байдлыг үүсгэхгүй байх, хууль эрх зүй, хяналтын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, нөхцөлүүдийг урьдчилан хангасан байх шаардлагатай юм.

Дээр дурдсанчлан, эрх бүхий байгууллагуудын зүгээс гадаадын банкны охин компани, салбар нэгжид үйл ажиллагааны зөвшөөрөл олгох шийдвэрийг тухайн улсын санхүүгийн салбарын тогтвортой байдал ба үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах (efficiency) хувилбарын тэнцвэрийг хэрхэн тогтоохоос ихээхэн хамаарна<sup>26</sup>. Өөрөөр хэлбэл, уг асуудлыг Монгол улсын санхүүгийн салбарт тулгарч буй хүндрэлүүд, макро эдийн засгийн орчин, системийн болон банк тус бүрийн эрсдэлийн түвшин, улс төрийн нөлөөлөл, хууль зүй, хяналтын орчин зэргийг дэнслэн үзэхгүйгээр олон улсаас амжилттай хэрэгжүүлсэн жишгээр шууд тусган хэрэгжүүлэх нь оновчтой сонголт биш юм<sup>27</sup>.

Иймд цаашид Монголбанк болон бусад эрх бүхий байгууллагуудын зүгээс гадаадын банкны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн тохиолдолд Монгол улсын санхүүгийн салбарын онцлог, үндэсний аюулгүй байдалтай холбоотойгоор нөлөөлж болох бүхий л хүчин зүйлсийг харгалзан үзэж, бодитой нөлөөллүүдийг судалсны үндсэн дээр шийдвэр гаргах нь зүйтэй байна.

<sup>26</sup> IMF 2011 – Staff discussion note: Subsidiary or branches? Does one size fit all?

<sup>27</sup> Montreevat, S.Rajan 2003 – Financial Crisis, Bank restructuring and Foreign bank entry: An analytic case study of Thailand